

# УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГААС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



**УЛСЫН БҮРТГЭЛ** ЭДИЙН ЗАСГИЙН ИЛ ТОД  
БАЙДЛЫГ ДЭМЖИХ ТУХАЙ  
ХУУЛЬ,

## ГАРЫН АВЛАГА



### ХЭН?

- Хувь хүн
- Хуулийн этгээд

### ЮУГ?

2015.04.01-ээс өмнөх  
бүртгүүлээгүй,  
нуун дарагдуулсан  
эд хөрөнгө,  
үйл ажиллагааг

### ХЭЗЭЭ, ХААНА?

2015.12.31-ийг  
дуустал холбогдох  
бүртгэлийн  
байгууллагад

### ХЭРХЭН?

Сайн дурын үндсэн  
дээр, шинээр  
бүртгүүлсэн, нөхөн  
мэдүүлсэн тохиолдолд

**Хариуцлагаас  
нэг удаа  
чолоолно.**

[iltod.mta.mn](http://iltod.mta.mn)



**“Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль”**-ийн дагуу санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлан, барааны мэдүүлэг, эд хөрөнгийн бүртгэлийг ил тодоор шинэчлэн бүртгүүлж, тайлагнах талаарх зөвлөгөө мэдээллийг доорх хаяг, утсанд хандаж аварай.

[iltod.mta.mn](http://iltod.mta.mn)

**ТАТВАРЫН АСУУДЛААР-1800-1288 /3, 4/**

[www.mta.mn](http://www.mta.mn)

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН АСУУДЛААР-1800-1289;**

[www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn)

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН АСУУДЛААР-7000-1890, 1800-1890;**

[www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn)

**ГААЛИЙН АСУУДЛААР-1800-1281;**

[www.customs.gov.mn](http://www.customs.gov.mn)

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР-51-263069, 51-264966**

[www.iltod.e-balance.mof.gov.mn](http://www.iltod.e-balance.mof.gov.mn)

## ХЭН?

- Хувь хүн,
- Хуулийн этгээд

## ЮУГ?

- Улсын бүртгэлд бүртгүүлээгүй, нуун дарагдуулсан эд хөрөнгө, үйл ажиллагаа
- Аливаа эрх олж авсан, эсхүл шилжүүлсэн тухай зайлшгүй бүртгүүлэх ёстой боловч бүртгүүлээгүй гэрээ, хэлцэл, тогтоол, шийдвэр холбогдох өөрчлөлт
- Өмнө нь улсын бүртгэлд буруу ташаа, худал мэдүүлсэн болон алдаатай бүртгэлүүд
- Эд хөрөнгө, хуулийн этгээдийн Улсын бүртгэлд бүртгүүлээгүй бусад холбогдох нэмэлт өөрчлөлт

## ХЭЗЭЭ:

2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал

## ХЭРХЭН?

Иргэн, хуулийн этгээд нь өргөдөл, мэдүүлэгт хуульд заасан нотлох баримтаа хавсаргаж улсын бүртгэлийн байгууллагад ирүүлнэ.

ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ,  
ЗӨВЛӨГӨӨ

**1800-1890  
7000-1890**

[www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn)

Нийслэлд харьяалагдах эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн өргөдөл, мэдүүлгийг Улсын бүртгэлийн ерөнхий газар /100 айл дахь үйлчилгээний 3 дугаар байрны 107 тоот /, орон нутагт тухайн аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст тус тус хүлээж авна.

Иргэн, хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, мэдүүлгийг УБЕГ-ын даргын тушаалаар томилогдсон улсын бүртгэгч хүлээн авч бүртгэнэ.

Хуульд заасан мэдээллийн нууцыг задруулахыг хориглоно.

## ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ



Хуульд заасан хугацаанд өөрийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлээгүй тохиолдолд нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан байдаг. /Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн 27.5/


Улсын бүртгэлийн байгууллага нь ЭДИЙН ЗАСГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ Улсын бүртгэлд бүртгүүлэхээр гаргасан хуулийн этгээдийн холбогдох өөрчлөлтийг бүртгэхдээ **ТОРГУУЛЬ НОГДУУЛАХГҮЙ.**

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр үзүүлэх үйлчилгээний төрөл.

- 1.Хуулийн этгээдийг шинээр байгуулсан, эсхүл өөрчлөн байгуулсан
- 2.Хуулийн этгээдийн оршин байгаа газрын хаягийн өөрчлөлт
- 3.Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчийн талаарх мэдээллийн өөрчлөлт
- 4.Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан өөрчлөлт
- 5.Хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын өөрчлөлт
- 6.Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын өөрчлөлт
- 7.Хуулийн этгээдийн оноосон нэрийн өөрчлөлт
- 8.Хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт

- 9.Хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийн өөрчлөлт /тусгай зөвшөөрөлтэйгээс бусад/
10. Хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах хугацааны сунгалт
11. Хуулийн этгээдийн дүрэм, гэрээнд оруулсан өөрчлөлт

*Шаардлагатай загвар, маягыг /burtgel.gov.mn/-ээс татаж авч болно.*

-  Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэх хугацаа:
- Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн бүртгэлийг ажлын 5 хоногт шийдвэрлэнэ.
  - Бусад хуулийн этгээдийн бүртгэлийг ажлын 2 хоногт шийдвэрлэнэ.

Жич: Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан өөрчлөлт нь 2015 оны 04 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх хугацаанд гарсан бол Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд хамруулж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 27.5 дахь хэсэгт заасан хариуцлагаас нэг удаа чөлөөлнө.

## ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ




2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө:

Эрхийн улсын бүртгэлд эд хөрөнгөө бүртгүүлээгүй, нуун дарагдуулсан буруу ташаа, худал мэдүүлж, алдаатай бүртгүүлсэн бол ЭДИЙН ЗАСГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ улсын бүртгэлд хамруулж холбогдох **ЗӨРЧЛӨӨ АРИЛГАХ БОЛОМЖТОЙ.**

/Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн хүрээнд тухайн хөрөнгөө ил тод болгон бүртгүүлсэн тохиолдолд холбогдох татвар болон хуульд заасан бусад хариуцлагаас нэг удаа чөлөөлөх бөгөөд таны гаргасан мэдүүлгийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэх, гүйцэтгэх ажиллагаа явуулахгүй./

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр үзүүлэх үйлчилгээний төрөл:

- Эрхийн улсын бүртгэлд анх удаа бүртгэх
- Эрх шилжсэнийг бүртгэх
- Өмчлөх эрхтэй холбоотой бусад эрхийг бүртгэх
- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэх

 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх хугацаа:

- Анхны бүртгэлийг ажлын 5 хоногт
- Гэрээ хэлцлийг ажлын 3 хоногт
- Бүртгэлийн нэмэлт, өөрчлөлтийг 3 хоногт тус тус багтаан бүртгэнэ.

*Улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардлагатай бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, загвар маягыг burtgel.gov.mn цахим хуудасны "Эдийн засгийн ил тод байдал" цэснээс татаж авч болно.*

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг "Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувь хүн, хуулийн этгээд хуульд заасан татварын төрлөөр илүү төлөлт тайлагнах, улс, орон нутгийн төсвөөс аливаа авлага үүсгэхийг хориглоно.